

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР**

**Санамж:** 1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.  
2. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариултыг сонгоорой

1. Дараах ойлголтуудын аль нь нийгэмшлийн үйл явцын талыг илэрхийлсэн байна вэ? /1 оноо/
  - A. Нийгэмшлээр өөриймшүүлж буй соёл, туршлага, хэм хэмжээ, үнэт зүйлсийг илэрхийлнэ.
  - B. Нийгмийн соёл, туршлага, хэм хэмжээ, үнэт зүйлсийг хэрхэн яаж өөриймшүүлэх арга замыг илэрхийлнэ.
  - C. Нийгэмшлээр чухам хэнээс хэнд соёл, туршлага, үнэт зүйлс уламжлагдаж байгааг илэрхийлнэ.
  - D. Иргэдэд нийгмийн соёл, хэм хэмжээ, үзэл санаа, үнэт зүйлс, үнэлэмжийн төрх загварыг эзэмшүүлж нийгмийг уламжилж үлдээх үндсэн нөхцлийг илэрхийлнэ.
  - E. Хүмүүс байр сууринаасаа хамааран хүндэтгэл, үнэ цэнтэй бүхэнд хүрэх боломжийн хувьд өөр хоорондоо ялгагдаж байгааг илэрхийлнэ.
2. Цэгийн оронд тохирох хариултыг олно уу? ..... нь хаалттай асуулт болон түүнд нэмэлт болгож нээлттэй хариултын сонголт бүхий бүтэцтэй байдаг. Энэ нь: /1 оноо/
  - A. Ганцаарчилсан асуулт
  - B. Нээлттэй асуулт
  - C. Хаалттай асуулт
  - D. Хагас нээлттэй асуулт
  - E. Чөлөөт асуулт
3. Нийгэмшилт хүний насан туршид явагддаг хэмээх санааг анх удаа судлаач Орвиль Г.Брим дэвшүүлсэн байна. Тэгвэл түүний үзсэнээр насанд хүрэгчдийн нийгэмшилтийн шинж аль нь вэ? /1 оноо/
  - A. Суурь үнэлэмж баримжаалалд нөлөөлдөг.
  - B. Туршлага арга барил эзэмшихэд чиглэнэ.
  - C. Хэм хэмжээг эзэмшиж чаддаг.
  - D. Зан төлвийн сэдлийг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.
  - E. Дүрэм биелүүлэх, анхааралтай дуулгавартай байхад сургадаг.
4. Харилцан үйлдлийн хандлагын хүрээнд “Толинд туссан би” гэдэг ойлголтыг томъёолсон эрдэмтнийг нэрлэнэ үү? /2 оноо/
  - A. Т.Парсонс
  - B. К.Маркс
  - C. Р.Мертон
  - D. М.Вебер
  - E. Ч.Куули
5. Ахлах ангийн сурагчийн хувьд нийгмийн байр суурь өмнөхөөсөө өөр болж ойр тойрныхон, хүмүүс танаас дунд болон бага ангийн сурагчаас илүү нухацтай хариуцлагатай үйл байдал, үйлдлийг харж хүлээж байдаг. Энэ нь нийгмийн ямар ойлголтын жишээ вэ? /1 оноо/
  - A. Үүргийн зөрчил
  - B. Үүргийн шинж
  - C. Иргэний үүрэг
  - D. Нийгмийн үүрэг
  - E. Үүргийн тогтолцоо
6. Хүний сүрэглэн амьдрах ёсыг халж гарч ирсэн, бүдүүлгээр тэгшитгэн хуваарилах үндсэн дээр хамтын аж ахуйгаа хөтөлж, бие биенийгээ тэтгэх нэгдмэл зохион байгуулалт үүсгэж байгаад аажмаар задарсан нийгмийн нийтлэгийн хэлбэр аль нь вэ? /2 оноо/
  - A. Ястан
  - B. Аймаг
  - C. Овог
  - D. Үндэстэн
  - E. Угсаатан
7. Маш энгийн технологид суурилсан, илүүдэл бүтээгдэхүүн үйлдвэрлэдэггүй, цусан төрлийн холбоогоор холбогдсон шинжийг агуулсан нь нийгмийн ямар хэв маягт хамаарах ойлголт вэ? /2 оноо/
  - A. Аж үйлдвэржсэн нийгэм
  - B. Хөдөө аж ахуйн нийгэм
  - C. Тариалан, мал аж ахуйн нийгэм
  - D. Ан агнуур, түүврийн нийгэм
  - E. Аж үйлдвэржсэний дараах нийгэм
8. Үйлдвэрлэлийн өсөлт нь технологийн шинэчлэлийг шаардаж, шинжлэх ухааны хөгжилтэй уялдах болсныг социологич Э.Гидденс аж үйлдвэржсэн нийгмийн өөрчлөлтөд нөлөөлөгч ямар хүчин зүйлсэд хамааруулсан бэ? /1 оноо/
  - A. Хувь хүнээс хамаарсан хүчин зүйлс
  - B. Соёлын хүчин зүйлс
  - C. Улс төрийн хүчин зүйлс
  - D. Оюун санааны хүчин зүйлс
  - E. Эдийн засгийн хүчин зүйлс





18. Хүмүүс өөрсдийн тайлбар үзэл, ёс заншлыг үнэн зөв, тохиромжтой бөгөөд ёс суртахуунлаг гэж боддог ба өөр аж төрөх ёсыг бүдүүлэг гэж үзэх нь соёлын ямар үзлийн илрэл вэ?

/2 оноо/

- A. Дуализм  
D. Плюрализм
- B. Релятивизм  
E. Этноцентризм
- C. Универсал

19. Дараах бодомжуудын аль нь буруу томъёологдсон байна вэ?

/1 оноо/

- A. Соёл бол хүний амьдралд удамшлаар дамжин олгогддог чадвар юм.  
B. Соёл бол хүнийг хүн болгодог үнэт зүйл юм.  
C. Соёл бол хүний амьдралын бүх талыг хамарсан өргөн хүрээтэй үзэгдэл юм.  
D. Соёл нь хүмүүсийн хамтын амьдралын явцад тодорхой хэрэгцээг дагаж бүтээгддэг юм.  
E. Соёл бол хүн төрөлхтний бүтээсэн материаллаг болон оюуны бүх үнэт зүйл юм.

20. Урлагийн нийгмийн амьдралд гүйцэтгэх үүргүүдийг зөв харгалзуулна уу?

/2 оноо/

1	Гоо сайхны үүрэг	a	Ёс суртахууны төлөвшилд нөлөөлж, өөрийгөө олоход туслах
2	Бие хүн төлөвшүүлэх үүрэг	b	Сайхныг зохисгүй бүхнээс ялган салгаж, үнэлэлт дүгнэлт өгөх
3	Танин мэдэхүйн үүрэг	c	Нийгэм хүний амьдралын нарийн төвөгтэй үйл явдлуудын талаар мэдээлэл түгээдэг үнэ цэнтэй эх сурвалж

- A. 1b 2a 3c    B. 1a 2b 3c    C. 1c 2a 3b    D. 1a 2c 3b    E. 1c 2b 3a

21. НЭ=НН үед макро эдийн засагт ямар үзэгдэл бий болох вэ?

/1 оноо/

- A. Бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ өсч инфляци бий болно.  
B. Макро эдийн засагт тэнцвэр бий болно.  
C. Үйлдвэрлэсэн баялгийн борлуулалт буурснаар эдийн засаг уналтад орж ажилгүйдэл үүснэ  
D. Макро эдийн засагт ямар нэг сөрөг үзэгдэл бий болохгүй.  
E. Тохирох хариулт алга

22. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг тодорхойлохдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ?

/1 оноо/

- A. Эцсийн бараа үйлчилгээний өртөг байх  
B. Тухайн улсын хэмжээгээр буюу газар нутаг дээр үйлдвэрлэсэн байх  
C. Нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн байх  
D. Зах зээлд борлуулагдаагүй бараа бүтээгдэхүүн үйлчилгээг оруулж тооцох  
E. Эдийн засгийн салбар дах хууль бус үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг оруулж тооцохгүй байх

23. Банкнот гэж юу вэ?

/1 оноо/

- A. Компьютерийн тусламжтайгаар хийгддэг банкны тооцооны тогтолцоо  
B. Тодорхой хугацаанд өрөө төлөх тухай зээлдэгчийн хүлээсэн үүргийг гэрчилсэн өр төлөх баталгаа  
C. Банкны хадгаламжид үндэслэн нэг тооцооны данснаас нөгөөд мөнгө шилжүүлэх банк хоорондын тооцооны тогтолцоо  
D. Данснаас тодорхой хэмжээний мөнгө авах тухай өмчлөгчийн зөвшөөрөл  
E. Төв банкнаас гаргадаг мөнгөн тэмдэгт, банкны тасалбар

24. Төв банкнаас арилжааны банкны заавал хадгалуулах мөнгөний нөөцийн хэмжээг тогтоосон шалтгаануудыг дурьдахдаа илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

/2 оноо/

- A. Мөнгөн хуримтлал үүсгэх  
C. Эдийн засаг дахь нийт мөнгөний хэмжээг тохируулах  
D. Арилжааны банкны зээл олгох хэмжээг зохицуулах
- B. Аливаа эрсдэлээс сэргийлэх  
E. Тохирох хариулт алга



25. Бодит цалингийн хэмжээг зөв тодорхойлсон бодомжийг олно уу? **/1 оноо/**

- A. Үндсэн цалинг инфляцийн түвшинд харьцуулах
- B. Үндсэн цалинг хүн амын амьжиргааны түвшинд харьцуулах
- C. Нэрлэсэн цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд харьцуулах
- D. Нэрлэсэн цалинг инфляцийн түвшинд харьцуулах
- E. Тохирох хариулт алга

26. Эдийн засагт үнийн ерөнхий түвшин буурч мөнгө чангарах үзэгдлийг юу гэж нэрлэх вэ? **/1 оноо/**

- A. Хэрэглээний бараа, үйлчилгээний жин
- B. Инфляци
- C. Дефляци
- D. Хэрэглээний үнийн индекс
- E. Хэрэглээний сагс

27. Монгол улсын сангийн бодлогыг хариуцаж байдаг төрийн байгууллагыг юу гэж нэрлэдэг вэ? **/1 оноо/**

- A. Төв банк
- B. Сангийн яам
- C. Санхүүгийн зохицуулах хороо
- D. Гадаад явдлын яам
- E. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

28. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу? **/2 оноо/**

1	Маркетинг	a	Хэрэглэгчийн хэрэгцээг хангаж, ашиг олох зорилготой овсгоо самбаа бүхий хүмүүсийн ажил хэрэгч харилцаа холбоо
2	Менежмент	b	Хэрэглэгчийн эрэлтийг судалж тэдний хэрэгцээнд тохируулан ямар бараа, үйлчилгээгээр хэрхэн хангаж болох талаар мэдлэг олгодог ухаан
3	Бизнес	c	Хүмүүст аж ахуйг үр ашигтай эрхлэн хөтлөх талаар мэдлэг олгодог ухаан

- A. 1b 2a 3c
- B. 1a 2c 3b
- C. 1b 2c 3a
- D. 1c 2b 3a
- E. 1c 2a3b

29. Нөхөж бичнэ үү. Гадаад худалдааны бараа эргэлт гэдэг нь .....хэлнэ. **/2 оноо/**

- A. Бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад орнуудад борлуулахыг хэлнэ.
- B. Экспорт, импортын зөрүүг хэлнэ.
- C. Улс орнуудын хооронд бараа, үйлчилгээний шилжих хөдөлгөөнийг хэлнэ.
- D. Экспорт, импортын нийлбэрийг хэлнэ.
- E. Бүтээгдэхүүн үйлчилгээг гадаад орнуудаас худалдаж авахыг хэлнэ.

30. Төр татвараас гадна тодорхой төрлийн барааны импортод хязгаарлалт буюу квот тогтоож өгөх тохиолдол байдаг. Жишээ нь: Тухайн оронд жилд орох барааны тоо хэмжээг 20 мянган ширхэгээс хэтрүүлэхгүй байх гэх мэт. Ийм арга хэмжээг гадаад худалдааны ямар бодлого гэж нэрлэдэг вэ? **/2 оноо/**

- A. Капиталын бодлого
- B. Демпинг
- C. Санхүү мөнгөний бодлого
- D. Хөрөнгө оруулалтын бодлого
- E. Протекционист бодлого

31. Аль бодомж нь буруу вэ? **/1 оноо/**

- A. Засаглах арга гэдэг нь итгэл үнэмшил бий болгох, албадах, амлалт өгөх, хориг саад тавих, сүрдүүлэх, шууд ба шууд бус мэдээллийн хяналт тогтоох, шинэ зорилт шаардлага бий болгох зэрэг олон хэлбэртэй.
- B. Засаглалын объект гэдэг нь засаглалын субъектээр удирдуулж буй иргэд, нийгмийн хэсэг бүлэг, байгууллага, нийгэм юм.
- C. Засаглалын нөөц гэдэг нь улс төрийн засгийг гартаа авч, тогтоон барих хэрэгжүүлэх бололцоог олгож байдаг эдийн засаг, нийгэм, оюун санааны хүчин зүйлс, арга хэрэгслүүд юм.
- D. Засаглалын механизм гэдэг нь нийгмийн институт болон удирдлагын аппаратын тусламжтайгаар субъект өөрийн ноёрхолоо тогтоохыг хэлнэ.
- E. Улс төрийн засаглал гэдэг нь хууль цаазын үндэстэй, албадлагын тусгай аппаратад тулгуурладаг, хүн амыг нийтэд нь хамарч байдаг төвлөрсөн хэлбэр юм.



32. Эрх мэдлийг бүтэц-чиг үүргийн хандлагын онолоор хэрхэн тодорхойлдог вэ? /1 оноо/

- A. Эрх мэдэл гэдэг нь нийгмийн бүлгийн өөрсдийгөө зохион байгуулах арга хэрэгсэл
- B. Эрх мэдэл гэдэг нь улс төрийн зан үйлийн өвөрмөц хэв маяг
- C. Эрх мэдэл нь тавьсан зорилгоо хэрэгжүүлэх чадвар, үйл ажиллагаа
- D. Эрх мэдэл нь улс төрийг хэрэгжүүлэх хэрэгсэл
- E. Эрх мэдэл нь захирагч, захирагдагч хоёрын харилцааны нэг өвөрмөц шинж

33. Шийдвэр ба үйлдэл нь юуны тусламжтайгаар илрэн гардаг вэ? /1 оноо/

- A. Шаардлага
- B. Оролт
- C. Эргэх холбоо
- D. Хувиргалт
- E. Гаралт

34. Дараах бодомжуудын аль нь Аномик бүлгийг илэрхийлж байна вэ? /1 оноо/

- A. Хүмүүс голдуу яс, үндэс угсаа гарал, арьсны өнгө, шашин шүтлэг, нас хүйс зэрэг нийтлэгээрээ хамрагддаг бүлэг
- B. Өөрийн гэсэн зорилго чиглэлтэй зохион байгуулалттай бүлэг
- C. Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүний цугларалт, бослого үймээн
- D. Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектын шууд удирдлаган дор зохион байгуулалттай үүсгэн байгуулагддаг бүлэг
- E. Эдийн засаг, бизнесийн бүхий л салбарын эвсэл холбоод, ажил олгогчдын болон ажил хайгчдын тодорхой зорилготой бүлэглэл

35. Улс төрийн намыг ямар шалгуурыг үндэслэн эрх баригч нам, сөрөг нам гэж ангилдаг вэ? /2 оноо/

- A. Зохион байгуулалт ба үйл ажиллагаагаар нь
- B. Улс төрийн тогтолцоо /систем/-д эзэлж буй байр сууриар нь
- C. Улс төрийн чиг баримжаагаар нь
- D. Үзэл суртал агуулгаар нь
- E. Үйл ажиллагааны шинж чанараар нь

36. Сонгодог ардчиллын үзэл санааны гол зарчмыг тоочихдоо илүүц зүйл дурьдсан бол аль нь вэ? /2 оноо/

- A. Төр нь хүний нэр төр, эрх чөлөө, өмч хөрөнгийг хамгаалах
- B. Төрийн засаглалыг хэрэгжүүлэхэд ард түмэн нийтээрээ оролцох эрхтэй
- C. Олон түмэн өөрсдийн төр, засгаа сонгож байгуулдаг
- D. Нийгмийн бүх үзэгдэлд хатуу хяналт тогтоохыг эрмэлздэг
- E. Улс төрийн амьдралд иргэд тэгш эрхтэй оролцох

37. Социал төрийн мөн чанаруудыг зөв холбоно уу? /2 оноо/

1	Амьдралын наад захын баталгааг тогтоон хуульчлах	a	Хүний амьдралд жам ёсны болон цаг зуурын зовлон бэрхшээл тохиолдох үед төр туслах Жишээ нь: өндөр наслах, өвчин эмгэг тусах г.м.
2	Нийгмийн тэгш ёсыг эмзэг бүлгийн хүрээнд хамгаалах	b	Хүн өөрийгөө төдийгүй үр хүүхдээ асран тэжээх үүргээ биелүүлэх нөхцөлийг төрөөс хангаж өгөх.
3	Шаардлага тулгарсан үед иргэдэд туслалцаа үзүүлэх	c	Иргэд төр, хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй ч хувь хүнийхээ хувьд байгалиас харилцан адилгүй, тэгш бус байдаг бөгөөд үүнийг төр орхихгүй нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийн бодлогыг хуульчлан тусгадаг.

- A. 1c 2a 3b
- B. 1a 2c 3b
- C. 1b 2a 3c
- D. 1c 2b 3a
- E. 1b 2c 3a

38. “Урагшгүй төрийн төлөөлөгчдөөс цус урсгалгүй салах цорын ганц бололцоог ардчилал гэнэ” гэж хэн хэлсэн бэ? /2 оноо/

- A. К. Поппер
- B. У. Черчилль
- C. А. Линкольн
- D. Т. Жефферсон
- E. Ж. Локк



39. Төрийг байгууламжийнх нь хэлбэрээр юу гэж ангилдаг вэ? **/1 оноо/**  
 А. Парламентын, Ерөнхийлөгчийн, Холимог В. Хаант ба Бүгд найрамдах  
 С. Ардчилсан ба ардчилсан бус D. Нэгдмэл, холбооны, улсуудын холбоо  
 Е. Хэмжээт ба хэмжээгүй эрхт
40. Төрийн болон нийгмийн аюулгүй байдал, дэг журмыг тогтоох нь төрийн ямар чиг үүрэгт хамаарах вэ? **/1 оноо/**  
 А. Хянан шалгах үүрэг В. Гадаад үүрэг  
 С. Хэрэгжүүлэгч үүрэг D. Дотоод үүрэг E. Зохицуулах үүрэг
41. Үндсэн хуулийн цэц хэдэн гишүүнтэй байдаг вэ? **/1 оноо/**  
 А. 7 гишүүнтэй В. 6 гишүүнтэй С. 9 гишүүнтэй  
 D. 8 гишүүнтэй E. 5 гишүүнтэй
42. Гэрээ хэлцлийн үндсэн шинжид үл хамаарахыг олно уу? **/1 оноо/**  
 А. Гэрээ хуулийн хувьд хүчин төгөлдөр байх  
 В. Гэрээнд хоёр талын ашиг сонирхол бүрэн илэрхийлэгдээгүй байж болно  
 С. Гэрээ хийх өөрийн хүсэл зориг байх  
 D. Гэрээгээр тохиролцсон нөхцөлийг заавал биелүүлэх  
 E. Гэрээгээ биелүүлээгүй тохиолдолд албадлагын арга хэрэглэх
43. Гэрээ нь хуульд нийцээгүй бол түүнийг анхнаасаа хүчин төгөлдөр бус гэж үзэх эсвэл хүчин төгөлдөр бус гэж тооцдог байна. Тэгвэл хүчин төгөлдөр бус гэрээний шинжүүдийг дурьдахдаа илүүц зүйл нэрлэсэн бол олно уу? **/2 оноо/**  
 А. Талууд төвийг сахисан байх В. Талуудын ашиг сонирхлыг хохироосон  
 С. Хууль бусаар хийсэн D. Иргэнийг ноцтой төөрөгдүүлж хууран мэхэлсэн  
 E. Иргэнийг айлган сүрдүүлж хүч хэрэглэсэн
44. Нөхөж бичнэ үү. ....гэдэг иргэний эрх үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл /эс үйлдэл/-ийг хэлнэ. **/1 оноо/**  
 А. Мэдэгдэл В. Гэрээ С. Санал D. Гомдол E. Хэлцэл
45. Монгол улсын иргэний үндсэн үүрэг аль нь вэ? **/1 оноо/**  
 А. Байгаль орчноо хамгаалах В. Үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх  
 С. Хуулиар ногдуулсан албан татвар төлөх D. Эрүүл мэндээ хамгаалах  
 E. Хөдөлмөрлөх
46. Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхэд хамааралгүй өгөгдлийг олно уу? **/1 оноо/**  
 А. Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих  
 В. Үндсэн хуулийг зөв хэрэглэх талаар тайлбар гаргах  
 С. Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах  
 D. Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг магадлан шийдвэрлэх  
 E. Үндсэн хууль зөрчсөн тухай иргэний гаргасан өргөдөл мэдээллийг хүлээн авах
47. Хүүхдийн эрхийн конвенцид хүүхдийн эрхийг хангаж хамгаалахад баримтлах үндсэн зарчмуудыг зааж өгсөн байдаг. Тэгвэл доорх өгөгдлүүдийн аль нь хүүхдийн эрхийн үндсэн зарчимд хамаарахгүй вэ? **/2 оноо/**  
 А. Алагчлахгүй байх В. Халамж хамгаалалд байх  
 С. Хүүхдийн ашиг сонирхлыг эрхэмлэх D. Эрхийг нь бүрэн эдлүүлэх  
 E. Үзэл бодолд нь хүндэтгэлтэй хандах
48. Шүүх байгууллага ямар чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага вэ? **/1 оноо/**  
 А. Гэм бурууг тогтоох В. Шалгах С. Хяналт тавих  
 D. Өмгөөлөх E. Биелүүлэх



49. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, ил тод байдлын талаар мэдээлэл цуглуулах, бодлого, шийдвэрт үнэлэлт өгч, цаашид анхаарах санал зөвлөмж боловсруулдаг байх нь төртэй харилцагч иргэнд тавигдах нийтлэг шаардлагын аль нь вэ? **/2 оноо/**

- A. Санхүүжүүлэгч иргэн байх      В. Оролцогч иргэн байх      С. Мэдээлэлтэй иргэн байх  
D. Сонгогч иргэн байх              Е. Хяналт тавигч иргэн байх

50. Монгол улсын Үндсэн хуулинд “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй” хэмээн заасан байдаг. Энэхүү өгөгдлийн үзэл санаатай аль бодомж тохирохгүй байна вэ? **/2 оноо/**

- A. Хүн нийгэмд биеэ зөв авч явж бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэнэ.  
B. Хүн эрхээ эдлэхийн хамт үүргээ биелүүлэх ёстой.  
C. Хуулийг дээдлэн хүндэтгэж сахин биелүүлэх нь иргэний үндсэн үүрэг юм.  
D. Хүн эрх, эрх чөлөөгөө өөрийн хүслээр эдэлнэ.  
E. Хуулийг сахин биелүүлж хүний нэр төр, ашиг сонирхлыг хүндэтгэн дээдэлнэ.

51. Олон улсын хэм хэмжээнд үл хамаарах өгөгдлийг олно уу? **/1 оноо/**

- A. Тодорхойлолтын хэм хэмжээ      В. Зарчмын хэм хэмжээ      С. Бүтцийн хэм хэмжээ  
D. Үүргийн хэм хэмжээ              Е. Хориглосон хэм хэмжээ

52. НҮБ-ын төв байр хаана байрладаг вэ? **/2 оноо/**

- A. Швейцарийн Женев хотод      В. Английн Лондон хотод      С. Францын Париж хотод  
D. Голландын Гаага хотод      Е. АНУ-ын Нью-Йорк хотод

53. Дараах өгөгдлүүдийн аль нь олон улсын харилцааны гурван туйлт системийн гол онцлог шинжийг илэрхийлж байна вэ? **/1 оноо/**

- A. Аль нэг талтай нь дайрсан ч тогтолцоог /системийг/ тогтворгүйжүүлэх хэрэггүй.  
B. Өөрсдийн хүчийг нэмэгдүүлэхийг байнга эрмэлздэг, нөгөө эвслийн гишүүнийг өөртөө татах, өөрийн гишүүдийг алдахгүйн төлөө тэмцдэг.  
C. Ноёрхогч шинжтэй болж буй аливаа улс, эвслийг эсэргүүцдэг.  
D. Өөрийн нөлөөнд буй улс орнуудын хоорондын зөрчилдөөнийг зохицуулах, эвсэлд нэгдсэн орнуудын салан тусгаарлах болон бие даах оролдлогыг таслан зогсоодог.  
E. Нөгөө хоёр талтай аль алинтай нь сайн харилцаатай байх, зөрчил үүсэхээс болгоомжилдог.

54. Дараах өгөгдлүүдийг зөв харгалзуулна уу. **/1 оноо/**

1	Олон улсын эрх зүй	a	Олон улсын харилцаанд оролцогч субъект бусад улсын өмнө хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд үүсэх хууль зүйн үр дагавар
2	Улс орнуудын хамтын ажиллагаа	b	Олон улсын харилцаанд оролцогч субъектүүдийн хоорондын харилцааг зохицуулдаг хууль зүйн зарчим, хэм хэмжээний тогтолцоо
3	Олон улсын эрх зүйн хариуцлага	c	Улс орнууд өөрсдийн нэн чухал эрх ашиг, сонирхлоо чухалчлахын зэрэгцээ бусдын эрх ашиг, сонирхлыг хүндэтгэх үндсэн дээр харилцан ойлголцож, төвөгтэй асуудлыг хамтран шийдвэрлэх үйл явц

- A. 1b 2c 3a      B. 1a 2c 3b      C. 1b 2a 3c      D. 1c 2b 3a      E. 1c 2a 3b

55. Дэлхийн олон нийтийн бие даасан гишүүн болсон эрхийн субъектүүдийн хоорондын харилцааг юу гэдэг вэ? **/1 оноо/**

- A. Хамтын харилцаа                      В. Дипломат харилцаа  
C. Олон улсын харилцаа              D. Найрсаг харилцаа  
E. Хүлээн зөвшөөрөх харилцаа

56. Олон улсын харилцаа гэх олон талт нийлмэл үйл явцын дотор багтах зөвхөн бие даасан тусгаар улсуудын төр, засгийн харилцааны хэсгийг онцгойлон судалдаг салбарыг юу гэж нэрлэдэг вэ? **/1 оноо/**

- A. Улс төрийн ухаан                      В. Дипломатын ухаан              С. Удирдлагын ухаан  
D. Харилцаа /коммуникаци /-ны ухаан      Е. Социологийн ухаан



**ХОЁРДУГААР ХЭСЭГ****Санамж:****1. Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг бөглөөрэй.****2. Зөв харгалзуулсан хариулт бүр 1 оноо**

2.1 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

**/6 оноо/**

a	Гэр бүл	1	Гэрлэсэн хосууд эхнэрийнхээ эцэг, эхийн гэрт амьдрах
в	Экзогами	2	Гэрлэсэн хосууд нөхрийн эцэг, эхийн гэрт амьдрах
с	Эндогами	3	Залуус шинэ нутаг сонгож, эцэг эхээсээ тусгаар амьдрах
d	Матрилокал	4	Гэрлэлтийг тодорхой бүлгийн дотоодод нь баталгаажуулдаг ёс
e	Патрилокал	5	Гэрлэлтийг тодорхой бүлгээс үл хамааруулан зохицуулах ёс
f	Неолокаль	6	Цусан төрөл, гэрлэлт, үрчлэлт, аж амьдрал зэргээр холбогдож, үр хүүхдийнхээ хүмүүжилд харилцан хариуцлага хүлээдэг хүмүүсийн нэгдэл

2.2 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

**/6 оноо/**

a	Зах зээл	1	Өөрийн бүтээгдэхүүнийг тогтвортой хэрэглэх хэрэглэгчтэй болохын тулд хямд үнэтэй, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх
в	Өрсөлдөөн	2	Аль болохоор бага зардлаар үр ашигтай үйлдвэрлэл явуулах бололцоо хангахуйц техник, технологи олж авах
с	Борлуулалтын өрсөлдөөн	3	Зар сурталчилгаагаар өрсөлдөх
d	Үнийн өрсөлдөөн	4	Бүтээгдэхүүн үйл ажиллагааны үр дүнг солилцохын тулд үйлдвэрлэгч, хэрэглэгч нар үнэ, тоо хэмжээг тодорхойлж харилцан ажиллах хүрээ
e	Технологийн өрсөлдөөн	5	Зах зээлд оролцогчдын хооронд үйлдвэрлэл болон бүтээгдэхүүнийг худалдах, худалдан авах талаар бусдаас давуутай нөхцлийг олж авахын төлөө явагдаж буй тэмцэл
f	Эрэлтийг бий болгох чадварын өрсөлдөөн	6	Зах зээлд эзлэх хувийн жингээ нэмэгдүүлэх

2.3 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

**/6 оноо/**

a	Эрх зүйн зохицуулалтын арга	1	Эсрэг тэсрэг сонирхол бүхий хүмүүс харилцан зөвшилцөлд хүрэх үйл явц
в	Иргэний хэрэг	2	Маргагч талууд маргааны талаар харилцан буулт хийх, эвийн хэлэлцээ байгуулах замаар маргааныг дуусгавар болгож, шийдвэрт хүрэх
с	Хэлэлцээ хийх	3	Иргэд, хуулийн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцаанд үүссэн нэхэмжлэл, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа
d	Зуучлах	4	Эдийн засаг, бизнес, худалдаа, хөрөнгө оруулалт зэрэг эдийн болон эдийн бус баялагтай холбоотой аливаа гэрээнээс үүссэн маргааныг талуудын тохиролцсоны үндсэн дээр хөндлөнгийн баг хянан шийдвэрлэх арга
e	Эвлэрэх	5	Төрийн зүгээс нийгмийн харилцаанд үзүүлэх нөлөөллийн арга
f	Арбитрт хандах	6	Аливаа маргаантай асуудлыг уг маргаанд холбоогүй хөндлөнгийн субъект оролцон талуудыг тодорхой зөвшилцөлд хүргэх, харилцан ойлголцуулах замаар шийдвэрлэх үйл явц

2.4 Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

**/6 оноо/**

a	Давхраажилт	1	Янз бүрийн угсаатан, үндэстэн зэрэгцэн амьдардаг нийгэм
в	Давхраажилтын хэмжигдэхүүн	2	Нэг бүлгийнхний зүгээс нөгөө бүлгээ тодорхойлдог үзэл бодол, хандлага
с	Давхраажилтын үндсэн хэв маяг	3	Нэг бүлэгт давуу боломж олгосон атлаа нөгөөгийнх нь боломжийг хааж буй бодит үйлдэл
d	Холимог нийгэм	4	Нийгмийн анги бүлгүүд нэг нь нөгөөгөөсөө нэр хүнд, эд баялаг, эрх мэдэл, боловсролоороо дээр юмуу, доор байрлах байдал
e	Бурангуй үзэл	5	Нэр хүнд, эрх мэдэл, эд баялаг, боловсрол
f	Алагчлал	6	Боолчлол, каст, язгуур, анги

